



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг:
boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас: 99125777 Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.02.16 № 01/30
танай 2024.01.24-ны № 04 -т

ХОВД СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ШОЛПАНХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэг нь 7.2 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар, 2.8 сая төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авсан бөгөөд тайлант оны эцэст 11.7 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлжээ.

Аудитын гол асуудал

АДБООС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд 9 хөтөлбөрийн хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, 90 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,311,329.1</u>	<u>62,751,455.0</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	40,898,563.0
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	40,898,563.0
3121	Төгрөг	-	40,898,563.0
31211	Төрийн сангийн харилцах	-	40,898,563.0
33	АВЛАГА	693,042.1	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	640,256.1	-
335	Бусад авлага	52,786.0	-
3351	Байгууллагаас авах авлага	52,786.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	17,618,287.0	21,852,892.0
354	Хангамжийн материал	17,618,287.0	21,852,892.0
35410	Бичиг хэргийн материал	83,000.0	22,500.0
35420	Аж ахуйн материал	2,921,180.0	1,543,100.0
35460	Хүнсний материал	7,815,957.0	11,773,582.0
35470	Бусад хангамжийн материал	6,798,150.0	8,513,710.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>213,196,850.9</u>	<u>213,735,907.6</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	213,196,850.9	213,735,907.6
392	Биет хөрөнгө	205,243,050.9	205,782,107.6
39201	Барилга, байгууламж, орон сууц	170,272,480.0	170,272,480.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,351,498.9)	(14,189,373.6)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,459,756.0	30,519,656.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,837,039.9)	(19,415,123.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,698,182.8	27,698,182.8
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,672,353.2)	(22,110,571.1)
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,268,990.0	38,268,990.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,079,295.0)	(5,745,961.7)
39217	Ном	483,829.0	483,829.0
393	Биет бус хөрөнгө	7,953,800.0	7,953,800.0
39301	Програм хангамж	457,000.0	457,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	7,496,800.0	7,496,800.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>231,508,180.0</u>	<u>276,487,362.6</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>217,922.0</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	217,922.0	-
413	Өглөг	217,922.0	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	217,922.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>231,290,258.0</u>	<u>276,487,362.6</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	231,290,258.0	276,487,362.6
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	59,467,248.0	59,467,248.0
512	Хуримтлагдсан үр дүн	60,417,489.2	105,614,593.8

51210	Өмнөх үеийн үр дүн	60,417,489.2	60,417,489.2
51220	Тайлант үеийн үр дүн	-	45,197,104.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,405,520.8	111,405,520.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	231,508,180.0	276,487,362.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	336,509,705.0	467,720,160.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,920,705.0	8,975,560.0
120	Нийтлэг татварын бус орлого	20,920,705.0	8,975,560.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,920,705.0	8,975,560.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,920,705.0	8,975,560.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,589,000.0	458,744,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	315,589,000.0	422,949,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,961,000.0	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	278,628,000.0	422,949,200.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	35,795,400.0
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	-	35,795,400.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	337,986,934.9	422,523,055.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337,986,934.9	422,523,055.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,986,934.9	422,523,055.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,720,985.2	234,140,612.6
210101	Үндсэн цалин	164,927,232.2	228,306,751.4
210102	Нэмэгдэл	52,249,954.0	5,193,605.0
210104	Урамшуулал	1,543,799.0	-
210105	Гэрээт ажлын хөлс	-	640,256.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,501,746.4	67,989,632.9
210201	Тэтгэврийн даатгал	17,416,573.1	67,989,632.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,195,523.9	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,652,394.9	-
210204	Ажилгүйдлийн даатгал	437,963.2	-
210205	Эрүүл мэндийн даатгал	4,799,291.3	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,997,414.0	34,744,177.0
210301	Гэрэл, цахилгаан	1,171,114.0	2,571,762.0
210302	Түлш, халаалт	20,505,300.0	31,922,415.0
210303	Цэвэр, бохир ус	321,000.0	250,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	7,069,200.0
210401	Бичиг хэрэг	-	2,578,700.0
210402	Тээвэр, шатахуун	-	3,515,500.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	975,000.0
2105	Нормативт зардал	31,486,950.0	40,626,775.0
210502	Хоол, хүнс	31,486,950.0	40,626,775.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	940,000.0
210604	Урсгал засвар	-	940,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	789,810.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	789,810.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,490,029.4	37,012,658.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,298,015.0	27,491,814.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,449,770.0	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,742,244.4	9,520,843.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,477,229.9)	45,197,104.6
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,477,229.9)	45,197,104.6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	61,894,719.2	232,767,488.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	61,894,719.2	232,767,488.0
C07	Тайлант үеийн үр дүн			(1,477,229.9)	(1,477,229.9)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	60,417,489.2	231,290,258.0
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	60,417,489.2	231,290,258.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	60,417,489.2	231,290,258.0
D08	Тайлант үеийн үр дүн			45,197,104.6	45,197,104.6
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	105,614,593.8	276,487,362.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	315,589,000.0	458,744,600.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,589,000.0	458,744,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	315,589,000.0	458,744,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,961,000.0	35,795,400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	278,628,000.0	422,949,200.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	315,589,000.0	417,846,036.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315,589,000.0	417,846,036.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	315,589,000.0	417,846,036.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,185,000.0	282,665,151.7
210101	Үндсэн цалин	163,614,408.1	190,893,434.0
210102	Нэмэгдэл	40,206,671.1	78,183,937.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	97,500.0
210104	Урамшуулал	14,363,920.8	13,490,280.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,540,700.0	39,377,885.0

210201	Тэтгэврийн даатгал	16,740,500.0	27,532,785.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,115,100.0	2,752,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,711,500.0	2,359,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	428,300.0	590,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,545,300.0	6,143,300.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,326,400.0	34,855,400.0
210301	Гэрэл, цахилгаан	1,320,212.0	2,532,985.0
210302	Түлш, халаалт	20,606,188.0	31,922,415.0
210303	Цэвэр, бохир ус	400,000.0	400,000.0
2105	Нормативт зардал	39,060,000.0	44,803,100.0
210502	Хоол, хүнс	39,060,000.0	44,803,100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	150,000.0	940,000.0
210604	Урсгал засвар	150,000.0	940,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.0	679,700.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.0	679,700.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,734,900.0	14,524,800.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,034,900.0	12,485,800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,700,000.0	2,039,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	40,898,563.3
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	40,898,563.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	40,898,563.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	458,744,600.0	417,846,036.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,744,600.0	417,846,036.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,744,600.0	417,846,036.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	322,390,500.0	282,665,151.7
210101	Үндсэн цалин	218,938,200.0	190,893,434.0
210102	Нэмэгдэл	94,364,500.0	78,183,937.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт		97,500.0
210104	Урамшуулал	9,087,800.0	13,490,280.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,048,100.0	39,377,885.0
210201	Тэтгэврийн даатгал	26,552,900.0	27,532,785.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,123,900.0	2,752,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,499,000.0	2,359,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	624,800.0	590,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,247,500.0	6,143,300.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,855,400.0	34,855,400.0
210301	Гэрэл, цахилгаан	2,529,500.0	2,532,985.0
210302	Түлш, халаалт	31,925,500.0	31,922,415.0

210303	Цэвэр, бохир ус	400,000.0	400,000.0
2105	Нормативт зардал	46,306,100.0	44,803,100.0
210502	Хоол, хүнс	46,306,100.0	44,803,100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	940,000.0	940,000.0
210604	Урсгал засвар	940,000.0	940,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	679,700.0	679,700.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	679,900.0	679,900.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,524,800.0	14,524,800.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,485,800.0	12,485,800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,039,000.0	2,039,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	458,744,600.0	458,744,600.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	422,949,200.0	422,949,200.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,795,400.0	35,795,400.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		40,898,563.3

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант онд нэмэлт дансаар санхүүжилт аваагүй байна.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,032.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,715.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Аудитаар нийт 1,715.5 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Тайлант онд үнэ төлбөргүй ирсэн 20 ширхэг 1,715.5 мянган төгрөгийн зөөлөн эдлэлийг бараа материалд орлого авч бүртгүүлсэн.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн 12 ажил гүйлгээг мэдээлээгүй байсныг shilendans.gov.mn сайтад нөхөж мэдээлүүллээ.

Залруулагдаагүй 3 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар 3 зөрчил² илэрснээс, 3,316.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант оны эцэст мах их хэмжээгээр нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хэрэгцээ шаардлагаас хэтрүүлэн худалдан авалт хийхгүй байх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хоол хүнсний зардлаар худалдан авалт хийж аж ахуйн материалд 1,712.3 мянган төгрөгөөр орлого авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоол хүнсний зардал, зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.

3. Цалин нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Батлагдаагүй орон тоонд бичиг хэрэг хавсарсны нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 16.5.3. “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”; 16.5.9. “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.6. “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бичиг хэрэг хавсарсны нэмэгдлийг зогсоох, шаардлагатай бол дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөл авч уг нэмэгдлийг олгох эсэхийг шийдвэрлэх.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Ховд сумын Хүүхдийн цэцэрлэг	Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлээгүй	1	0	1	0			1	0				
	Үнэ төлбөргүй ирсэн зөөлөн эдлэлийг орлого авч бүртгээгүй	1	1,715.5	1	1,715.5			1	1,715.5				
Нийт дүн		2	1,715.5	2	1,715.5			2	1,715.5				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Ховд сумын Хүүхдийн цэцэрлэг	Хоол хүнсний зардлаас аж ахуйн материалд орлого авч зарцуулсан.	1	1,712.3					1	1,712.3		
	Тайлант оны эцэст мах их хэмжээгээр нөөцөлсөн.	1	0					1	0		
	Батлагдаагүй орон тоонд бичиг хэрэг хавсарсны нэмэгдэл олгосон.	1	1,604.4					1	1,604.4		
Нийт дүн		3	3,316.7					3	3,316.7		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан				

A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТК								
5	ТЕЗ								
	Нийт	1	1			1			